БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлүүн сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/60/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: кhuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Назгүл<br>Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 13
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 16
4.1 Ерөнхий зүйл ..... 16
4.2 Материаллаг байдал ..... 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 18
5.1 Төлбөрийн акт ..... 18
5.2 Албан шаардлага ..... 18
5.3 Зөвлөмж ..... 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| БСШУСС | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.24 № 190
танай ______-ны № ______-т

ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С. АМАНКЕЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дүгнэлт-Дэлүүн ЗДТГ-02.24-ТА

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Дүгнэлт-Дэлүүн ЗДТГ-02.24-ТА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **107,633,017.98** | **167,247,527.98** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 92,634,289.98 | 102,740,049.98 |
| **354** | **Хангамжийн материал** | 24,134,291.98 | 34,240,051.98 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 91,202.00 | 91,202.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,489,299.98 | 8,843,299.98 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 21,240.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,532,550.00 | 25,305,550.00 |
| 35600 | Мал амьтад | 68,499,998.00 | 68,499,998.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 14,998,728.00 | 64,507,478.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | 14,998,728.00 | 64,507,478.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,065,755,679.24** | **2,249,438,270.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,065,755,679.24 | 2,249,438,270.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,057,631,079.24 | 2,237,513,670.98 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,456,401,395.00 | 1,598,418,495.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (290,234,387.34) | (374,010,039.04) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 67,859,986.00 | 257,459,986.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (32,351,940.95) | (50,433,367.25) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 339,680,309.30 | 369,923,609.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (194,467,787.74) | (221,288,383.26) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 76,430,604.00 | 77,680,604.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (33,264,264.72) | (40,363,012.22) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 560,258,486.00 | 560,258,486.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (35,748,618.48) | (58,799,157.84) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 331,660,218.74 | 335,410,218.74 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (188,592,920.57) | (216,743,768.45) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,124,600.00 | 11,924,600.00 |
| 39301 | Програм хангамж | 1,333,400.00 | 5,133,400.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,333,400.00) | (1,333,400.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,124,600.00 | 8,124,600.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,173,388,697.22** | **2,416,685,798.96** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,124,500.00** | **15,800,000.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,124,500.00 | 15,800,000.00 |
| **413** | **Өглөг** | 4,124,500.00 | 15,800,000.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 4,124,500.00 | 14,600,000.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 1,200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 1,200,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,169,264,197.22** | **2,400,885,798.96** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,169,264,197.22 | 2,400,885,798.96 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 744,160,007.00 | 744,160,007.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 744,160,007.00 | 744,160,007.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,312,499,838.42 | 1,544,121,440.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,261,565,061.26 | 1,312,499,838.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 50,934,777.16 | 231,621,601.74 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 112,604,351.80 | 112,604,351.80 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,173,388,697.22** | **2,416,685,798.96** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **710,451,801.00** | **1,098,315,450.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **58,000,428.00** | **58,486,750.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 58,000,428.00 | 58,486,750.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 58,000,428.00 | 58,486,750.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 43,001,700.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 14,998,728.00 | 58,486,750.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **652,451,373.00** | **1,039,828,700.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,867,731.00 | 8,048,800.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,750,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,117,731.00 | 4,882,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 3,166,800.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 642,581,691.00 | 1,031,779,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 455,789,700.00 | 619,082,200.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 186,791,991.00 | 367,366,100.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 00.00 | 45,331,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,001,951.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 3,001,951.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **659,517,023.84** | **866,693,848.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **659,517,023.84** | **866,693,848.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 642,286,712.84 | 729,335,117.26 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 328,176,206.00 | 360,992,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 212,702,006.00 | 211,125,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 70,622,900.00 | 81,089,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 44,851,300.00 | 68,777,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,216,286.00 | 44,919,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,415,622.00 | 30,613,061.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,202,327.00 | 3,606,366.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,558,404.00 | 2,885,091.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 639,601.00 | 710,415.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,400,332.00 | 7,104,167.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,749,760.00 | 28,266,240.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,314,160.00 | 979,740.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,335,600.00 | 26,786,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,462,684.00 | 67,166,520.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,350,600.00 | 4,825,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,709,086.00 | 53,089,820.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,011,298.00 | 2,348,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,168,750.00 | 6,902,900.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 18,222,950.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,745,500.00 | 1,100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,745,500.00 | 1,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,657,512.00 | 7,487,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,657,512.00 | 7,487,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,239,040.00 | 1,700,669.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150,400.00 | 527,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 302,200.00 | 323,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 84,740.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 96,700.00 | 183,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 398,700.00 | 398,630.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 7,839.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 94,000.00 | 94,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 191,582,724.84 | 217,245,588.26 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,079,463.00 | 29,867,780.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 400,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 149,003,261.84 | 186,977,808.26 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17,230,311.00 | 137,358,731.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 45,331,600.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | 45,331,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,215,251.00 | 91,957,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 3,001,951.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 00.00 | 43,897,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,213,300.00 | 48,060,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 15,060.00 | 69,931.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,060.00 | 69,931.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **50,934,777.16** | **231,621,601.74** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **50,934,777.16** | **231,621,601.74** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **508,661,082.00** | **672,462,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **43,001,700.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 43,001,700.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 43,001,700.00 | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 43,001,700.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **465,659,382.00** | **672,462,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,867,731.00 | 8,048,800.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 4,750,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,117,731.00 | 4,882,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 3,166,800.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 455,789,700.00 | 664,413,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 455,789,700.00 | 619,082,200.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 45,331,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,001,951.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 3,001,951.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **494,771,082.00** | **669,168,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **494,771,082.00** | **669,168,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **477,540,771.00** | **531,809,569.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 326,928,100.00 | 360,992,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 211,453,900.00 | 211,125,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 70,622,900.00 | 81,089,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 44,851,300.00 | 68,777,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,685,300.00 | 44,919,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,208,200.00 | 31,363,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,369,200.00 | 3,388,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,695,400.00 | 2,711,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 673,900.00 | 677,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,738,600.00 | 6,777,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,732,500.00 | 28,245,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,314,160.00 | 979,740.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,318,340.00 | 26,765,260.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 30,662,656.00 | 54,095,020.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,244,602.00 | 4,825,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,370,256.00 | 40,069,320.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,011,298.00 | 2,348,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,036,500.00 | 6,851,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,293,300.00 | 1,100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,293,300.00 | 1,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,657,512.00 | 7,487,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,657,512.00 | 7,487,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,239,040.00 | 1,700,669.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 150,400.00 | 527,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 302,200.00 | 323,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 84,740.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 96,700.00 | 183,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 398,700.00 | 398,630.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 7,839.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 94,000.00 | 94,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 43,885,363.00 | 32,812,780.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,385,363.00 | 32,412,780.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 400,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **17,230,311.00** | **137,358,731.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | 45,331,600.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | 45,331,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,215,251.00 | 91,957,200.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 3,001,951.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 43,897,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,213,300.00 | 48,060,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 15,060.00 | 69,931.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,060.00 | 69,931.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **13,890,000.00** | **3,294,300.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **13,890,000.00** | **3,294,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **13,890,000.00** | **3,294,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 13,890,000.00 | 3,294,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 13,890,000.00 | 3,294,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(13,890,000.00)** | **(3,294,300.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 744,160,007.00 | 173,035,819.80 | 1,201,133,593.26 | 2,118,329,420.06 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 60,431,468.00 | 60,431,468.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **744,160,007.00** | **173,035,819.80** | **1,261,565,061.26** | 2,178,760,888.06 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | -60,431,468.00 | | -60,431,468.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 50,934,777.16 | 50,934,777.16 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **744,160,007.00** | **112,604,351.80** | **1,312,499,838.42** | 2,169,264,197.22 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **744,160,007.00** | **112,604,351.80** | **1,312,499,838.42** | **2,169,264,197.22** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **744,160,007.00** | **112,604,351.80** | **1,312,499,838.42** | **2,169,264,197.22** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 231,621,601.74 | 231,621,601.74 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **744,160,007.00** | **112,604,351.80** | **1,544,121,440.16** | 2,400,885,798.96 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 664,413,800.00 | 664,343,869.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 664,413,800.00 | 664,343,869.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 527,125,000.00 | 527,055,069.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 360,992,800.00 | 360,992,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 211,125,700.00 | 211,125,700.00 |
| 210102 | Нэмэгдэл | 81,089,900.00 | 81,089,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 68,777,200.00 | 68,777,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,919,100.00 | 44,919,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,363,500.00 | 31,363,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,388,900.00 | 3,388,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,711,100.00 | 2,711,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 677,800.00 | 677,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,777,800.00 | 6,777,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 28,245,000.00 | 28,245,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 865,000.00 | 979,740.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,880,000.00 | 26,765,260.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 52,244,000.00 | 52,244,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,791,800.00 | 4,825,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 37,115,500.00 | 36,852,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,068,700.00 | 2,298,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,268,000.00 | 8,268,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 457,000.00 | 457,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 457,000.00 | 457,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 6,887,200.00 | 6,887,200.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,887,200.00 | 6,887,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,770,600.00 | 1,700,669.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 529,200.00 | 527,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 362,200.00 | 323,600.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 90,300.00 | 90,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 183,900.00 | 183,900.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 75,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 398,700.00 | 398,630.00 |
| 210807 | Газрын төлбөр | 37,300.00 | 7,839.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 94,000.00 | 94,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,509,300.00 | 30,509,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,109,300.00 | 30,109,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 400,000.00 | 400,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 137,288,800.00 | 137,288,800.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 45,331,600.00 | 45,331,600.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 45,331,600.00 | 45,331,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 91,957,200.00 | 91,957,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,897,200.00 | 43,897,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 48,060,000.00 | 48,060,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 664,413,800.00 | 664,343,869.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 664,413,800.00 | 664,343,869.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 619,082,200.00 | 619,012,269.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 45,331,600.00 | 45,331,600.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 34 | 38 |
| 620001 | Удирдах ажилтан | 15 | 14 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 8 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 |
| 620004 | Гэрээт ажилтан | 7 | 13 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **32** | **38** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9 | 8 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6 | 9 |
| 650010 | Гэрээт ажилтан | 3 | 7 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 14 | 14 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,048,800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,048,800.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 8,048,800.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,267,120.00 |

| | | |
|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,217,120.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 50,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 600,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,181,680.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,181,680.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 8,048,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 8,048,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,882,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,166,800.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хэрэгжүүлэх, иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон нийгмийн үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм.

Тайлант онд төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй. Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажил, ажлын цаг ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад *нийцсэн,* тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт *тохирсон* байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 243.3 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 0.00 | 0.00 |
| Авлага | 0.00 | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 107633.02 | 167247.53 | 59,614.51 |
| Үндсэн хөрөнгө | 2065755.68 | 2249438.27 | 183,682.59 |
| **Нийт хөрөнгө** | **2173388.70** | **2416685.80** | **243,297.10** |
| Өр төлбөр | 4124.50 | 15800.00 | 11,675.50 |

| | | | |
|---|---|---|---|
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2169264.20 | 2400885.80 | 231,621.60 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2173388.70** | **2416685.80** | **243,297.10** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Бараа материалын данс 59.6 сая төгрөгөөр нэмэгдсэн ба аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 58.5 сая төгрөгийн засвар үйлчилгээ, хөрөнгө, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 183.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 3.3 сая, үнэ төлбөргүй 367.4 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 187.0 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр данс 11.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тээвэр шатахууны өр төлбөр 13.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тайлант онд 231.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 231.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Орон нутгийн төсвөөс 651.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж орон нутгийн төсвөөс санхүүжих төсвийг 599.3 сая, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих төсвийг 45.3 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 619.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 45.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 619.1 сая төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сангаас 45.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 664.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | | | | |
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 360125.2 | 360093.9 | 31.3 | 99.9% |
| 2 | Туслах үйл ажиллагааны зардал | 151149.8 | 151111.2 | 38.6 | 99.9% |
| 3 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 48060.0 | 48060.0 | 0.00 | 100% |
| 4 | Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөний тэтгэмж | 43897.2 | 43897.2 | 0.00 | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Орон нутгийн нөөц хөрөнгө | 12550.0 | 12550.0 | 0.00 | 100% |
| 6 | Улсын их баяр наадам | 3300.0 | 3300.0 | 0.00 | 100% |
| 7 | ОНХС-аас итгэлцүүрээр олгох | 45331.6 | 45331.6 | 0.00 | 100% |
| | **Дүн** | **664413.8** | **664343.9** | **69.9** | 99.9 |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар нь  нь дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 4.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3.2 сая, нийт 8.1 сая төгрөгийг нэмэлт санхүүжилт авсан байна.

Тайлант онд тээвэр шатахууны зардалд  3.2 сая, шуудан холбооны зардалд 0.05 сая, дотоод албан томилолтын зардалд 0.6 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 4.2 сая, нийт 8.0 сая төгрөгийн зарцуулсан байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газар 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн  3/19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 656.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Дэлүүн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1098.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.9 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад тайлант онд батлагдсан төсвийг 69.9 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Тэтгэвэрт гарсан Засаг даргын тамгын газрын дарга, жолооч нарт тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгож, цалингийн зардлаас 1.6 сая төгрөгийн нэг сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмжийг давхар олгосон байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100% байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 93.2 сая төгрөгийн урсгал зардлын 10 хувиар 9.3 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчилд албан шаардлага, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах талаар зөвлөмж өгөгдсөн.Аудитаар хэрэгжилтийг давтан шалгахад 100 %-ийн биелэлттэй байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 1 | 9323.2 | 1 | 9323.2 | 100% |
| Зөвлөмж | 1 | 10300.0 | 1 | 10300.0 | 100% |
| **Нийт дүн** | **2** | **19623.2** | **2** | **19623.2** | **100%** |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

# 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

## 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

## 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

## 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тэтгэвэрт гарсан 2 хүнд тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгож, цалингийн зардлаас 1.6 сая төгрөгийн нэг сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмжийг давхар олгосон | 1 | 1621.8 | 1 | 1621.8 | | | | |
| Дүн | 1 | 1621.8 | 1 | 1621.8 | | | | |
| **Нийт дүн** | **1** | **1621.8** | **1** | **1621.8** | | | | |